



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар A/78

Улаанбаатар хот

┌ Журам батлах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 62 дугаар тогтоолын 3 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тушаалын 8 дахь заалт, Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны А/161 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн А/269 дугаар тушаалын наймдугаар хавсралт, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын даргын 2007 оны 474, 2016 оны 77 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүйтний улиралд коронавируст(COVID-19) халдварын үед тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, зоонозын өвчин судлалын төвийн дарга нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Б.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

ХҮЙТНИЙ УЛИРАЛД КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТҮР ЖУРАМ

НЭГ. Нийтлэг зүйл

Энэхүү журмын зорилго нь хүйтний улиралд коронавируст халдвар (КОВИД-19) олон нийтийн дунд тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

Гадна орчны агаарын температур 0 градус ($0C^0$)-аас доош хэмд "Хүйтний улиралд коронавируст (КОВИД-19) халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр журам"-аар зохицуулагдана.

1. Хилээр нэвтрүүлж буй бүх төрлийн тээврийн хэрэгслийг урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтэд хамруулж, МХЕГ-ын даргын 2007 оны 474, 2016 оны 77 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан аргачлалд дурьдсаны дагуу гүйцэтгэх /хүйтний улиралд хуурай хуурай бодисоор туулуулах аргыг ашиглаж болно/
2. Хилийн боомт болон гүний гаалийн хяналтын бүс дээр халдвар тархах нөхцөл, дамжих замыг тодорхойлж, эрсдэл бүхий орчин, гадаргууд чиглэсэн халдваргүйжүүлэлтийг хийх /Жишээ нь жолоочийн хүрэлцэхүйц эд зүйлс болох бүхээгий дотор гаднах гадаргуу, бариул жолооны хүрд, толь, гишгүүр, ачааны эд анги гэх мэт /
3. Хүйтний улиралд тээврийн хэрэгсэл, жолооч, зорчигчийн эд зүйлс, хүрэлцэхүйц гадаргууг утах, мананцаржуулах болон хэт ягаан болон спиртийн уусмалаар халдваргүйжүүлэх нь тохиромжтой тул дээрх аргуудыг өөрийн нөхцөлд тохируулан сонгон хэрэглэх
4. Монгол Улсын Шадар сайд, УОК-ын даргын баталсан "Коронавируст халдварын үед уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журам"-ын 2.3-д заасны дагуу халдваргүйжүүлэлтийн байгууламжийг дулаалж тоноглох үүргийг экспортын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд өгч, аймаг орон нутгийн Онцгой комисст танилцуулж шийдвэрлэх
5. Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй жолооч нарыг халдвараас сэргийлэх дэглэм, ариутгал, халдваргүйжүүлэлтийн талаар үе шаттайгаар сургалтад хамруулах

Хоёр. Халдваргүйжүүлэлтийн түр байр

- 2.1. Хилийн боомт болон гүний гаалийн хяналтын бүсэд халдваргүйжүүлэлт хийх түр байрыг байгуулж, дотоод орчинд халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэнэ.
- 2.2. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх зориулалттай түр байрыг сэндвич хавтангаар барина.
- 2.3. Түр байр дараах шаардлагыг хангасан байх

- 2.3.1. Урт 20м, өргөн 5м, өндөр 4.8 м
- 2.3.2. Дулаан алдагдал бага байх
- 2.3.3. Ус чийгнээс хамгаалагдсан хүйтэнд тэсвэртэй байх
- 2.3.4. Удаан эдэлгээтэй найдвартай бат бөх чанартай байх
- 2.3.5. Галд тэсвэртэй, галын аюулгүй байдлыг хангасан байх
- 2.3.6. Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг нь хангалттай сайн байх
- 2.3.7. Хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй
- 2.3.8. Ус нэвтэрч, нэвчдэггүй, мөөгөнцөр үүсэхээргүй байх
- 2.3.9. Тээврийн хэрэгсэл орох, гарах хаалга нь нэг урсгалтай байх
- 2.3.10. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх нөхцлийг бүрэн хангасан байх
- 2.3.11. Түр байрны дотоод орчны агаарын хэм тэгээс дээш хэмийн дулаан байхаар зохицуулагдсан халаалттай байх
- 2.3.12. Түр байрны орох хэсэгт 4-5 метр урттай тээврийн хэрэгслийн дугуйг хуурайгаар халдваргүйтгэх халдваргүйтгэлийн бодис бүхий замтай байх

Гурав. Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх

- 3.1 Тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дугаар тушаалын наймдугаар хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хугацаа

- 4.1 Энэхүү түр журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

Тав. Бусад

- 5.1 Энэхүү түр журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, жолооч, ажилтан, иргэдэд Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.